



БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ

Д.ЗАГДЖАВ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ,  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР ХУУЛЬД  
ЗААСАН ШААРДЛАГАД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААР ДҮГНЭЛТ ГАРГАХ  
ЗӨВЛӨХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 02 дүгээр ... сарын  
05 -ний өдөр

Дугаар УАГ-АД / Улаанбаатар хот  
/2024-04

**Ажлын зорилго**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас “Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах” аргачилсан заавар, шалгах хуудас боловсруулах, аудитад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллахад чиглэгдэнэ.

**Эхлэх хугацаа:** 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

**Дуусах хугацаа:** 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

**Байршил:** Засгийн газрын 4 дүгээр байр

**НЭГ ҮНДЭСЛЭЛ**

Дүгнэлт гаргах аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

**ХОЁР АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6. “Нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрөөс өмнө сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс боловсруулж ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

**ГУРАВ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ**

Шинжээч дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
-----	-----------------------	----------	---------	------------------

1	Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж дүгнэлт гаргахад баримтлах аргачилсан заавар, хуульд заасан шаардлагад нийцэж буй эсэхийг шалгах хуудас тус тус боловсруулах,	Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээ, ажлын даалгаварт тусгасан ажлын төлөвлөсөн хугацаа	Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах аргачилсан заавар боловсруулах, аудитад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллах.	“Алсын хараа 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого,  Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль,  Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,  Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
2	Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээг аргачилсан зааврын дагуу хянаж дүгнэлт гаргахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;  Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, боловсруулсан аргачлал, шалгах хуудсын талаар мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх.			Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр.  Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/  Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар гүйцэтгэсэн аудитын дүгнэлт, аргачилсан заавар, шалгах хуудас
3				

### **ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ**

- Шинжээчийн тайлан нь албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байх /мөр хоорондын зай “single” үсгийн хэмжээ 12/ бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.

- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.

- Тайлан, дүгнэлт боловсруулахад шалгуур болгон ашигласан хууль, стандартын норм, дүрэм зэрэг мэдээллийн эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан зорилгыг хэрэгжүүлэхдээ Төрийн аудитын тухай хууль, Төрийн аудитын стандарт, аудит хийх журмыг мөрдөж Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн боловсруулж ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр түүний зорилт арга хэмжээ нь холбогдох хууль, дүрэм, журам, бусад эрх зүйн актад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийн аудитын багийн гишүүдэд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллана.

Шинжээч нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах бөгөөд аудит гүйцэтгэхээр томилогдсон ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллаж, ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн, ажлын үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бичнэ.

## **ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Шинжээч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт туссан төрийн бодлого, санхүүгийн менежмент, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, зээл, татвар, нягтлан бодох бүртгэл, санхүү эдийн засаг, хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, дүн шинжилгээ хийх, үнэлэх чадвартай, тухайн салбарын талаар мэдлэг, дадлага, туршлагатай байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчийн ажлын хүрээнд мэргэшсэн, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн байх бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэх шинжээчид дараах шаардлага тавигдана. Үүнд:

- *Хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, шаардлагад нийцүүлэн судалгаа шинжилгээ хийж байсан, хууль зүйн магадлан шинжилгээ хийх, тайлан бэлтгэх, хууль зүйн дүгнэлт гаргах чадвартай;*
- *Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргахад ажиллаж байсан давуу талтай;*
- *Хууль, эрх зүйн бакалавр түүнээс дээш боловсрол эзэмшсэн, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан туршлага бүхий;*

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Ажлын даалгаврыг гүйцэтгэх шинжээч нь ажил эхлэхийн өмнө /Аудитын баг/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно мөн үе шатны ажлын явцад илэрсэн, хэрэгжүүлэх явцад үүссэн, шийдвэрлэх боломжгүй асуудал бий болсон тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

### **Бүрдүүлэх материал:**

- Шинжээчийн анкет, ажлын туршлагын талаарх товч намтар, боловсролын зэргийн диплом, мэргэшлийн гэрчилгээ, үнэмлэх, сертификатын хуулбар;

### **ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.